

ЗҮҮН ХОЙТ АЗИЙН БҮС НУТАГ, ОЛОН ТАЛТ  
ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ЗАРИМ АСУУДАЛ

Ч.Далай,  
Б.Балдоо

Хүн төрөлхтөн нэгэн зуун дуусч нөгөө зуун эхлэх босгонд тулж ирээд байна. Иймээс туулан өнгөрүүлж буй энэхүү үеэ ойлгон таних оролдлого хийх нь цаг үеийн нэгэн чухал шаардлага болж байна. Өнөөгийн олон улсын байдал хэдэн жилийн өмнөхөөс эрс өөр боллоо. "Хүйтэн дайны" үе нэгэнт дуусгавар болж дэлхий ертөнц хүчний хоёр туйлт тогтолцооноос олон туйлт тогтолцоонд шилжих үйл явц өрнөх болов. Үүнийг хуучин ЗХУ задарч АНУ-ын зонхилал ямар нэгэн хэмжээгээр алдагдаж, аюулгүй байдлын асуудлаарх олон улсын хамтын ажиллагаа цөөн хэдэн их гүрэнд хянагдахаа больж, олон талын яриа хэлцэлтэй холбогдсон олон асуудал бүс нутгуудын улсуудын гарт орох болж байгаатай холбон үзэж болох юм.

Олон улсын байдалд нааштай өөрчлөлт гарсан боловч улс орнуудын хооронд маргаан тэмцэл үргэлжилсээр, цэрэг дайны аюул, тогтворгүй байдлын үр уурхай үлдэн оршиж бас шинээр нэмэгдэн гарсаар байна. Үүнд өргөн уудам Ази тивийн бүс нутгийг ч хамааруулан хэлж болох байна.

Дэлхийн улс орнууд, ялангуяа жижиг, дунд орнууд амгалан тайван орчинд амьдарч, эдийн засгаа өөд татаж, ачаалал багатай гадаад бодлого явуулахыг эрмэлзэх болсон өнөө үед зэвсэглэлийг, тэргүүн ээлжинд цөмийн зэвсэглэлийг хорогдуулж, цөмийн зэвсэг дэлгэрүүлэхгүй байх явдал нэн чухал асуудал болон тавигдаж байна. Ингэснээр цөмийн зэвсгийг хорогдуулахаас хэмнэгдэх асар их хөрөнгийг улс түмний эдийн засаг, нийгмийн хөгжилд

- 
- Ч.Далай. ШУА-ийн Зүүнхойт Ази судлалын төвийн захирал, академич  
Б.Балдоо. ШУА-ийн Зүүнхойт Ази судлалын төвийн тэргүүлэх ажилтан, академич

зориулж чадвал хичнээн их ашигтай болох нь ойлгомжтой бөгөөд өнөө үед тийм шинэ боломж ч гарах төлөвтэй болж байна.

Өнөөдөр дэлхий дахинд өрнөж буй гол үйл явдлын нийгмийн амьдралыг ардчилах, эрх чөлөөг хүндэтгэх, эдийн засгийн хөгжлийн асуудалд тэргүүн зэргийн анхаарал тавих маргаантай асуудлыг шийдвэрлэхэд хүч хэрэглэхээс татгалзах түүнийг улс төрийн аргаар зохицуулах тийш чиглэгдэх болж байна.

Хүн төрөлхтний нийгэм-эдийн засгийн орчин үеийн нарийн төвөгтэй зорилтыг хэрэгжүүлэхэд НҮБ-ын үүрэг улам бүр нэмэгдэж, түүний үйл ажиллагаа нь идэвхжиж байна. Иймд НҮБ-ыг шинэ нөхцөл байдалд зохицуулан өөрчлөх, түүний үйл ажиллагаанд гишүүн улс бүр тэгш оролцон, дэмжих шаардлага өсч байна.

Хүн төрөлхтөн экологийн аюулгүй орчинд байгальтайгаа эвсэн, эдийн засгаа хөгжүүлэн амьдрах асуудал өнөөдөр хэзээ хэзээнээс илүү хурцаар тавигдаж байна. Үүнтэй холбогдон олон улсын хэллэг, толь бичигт "экогеоэкономик" гэсэн ухагдахуун ч бий болсон биз. Энэ чухал үзэл санаа 1992 онд Бразильд болсон Байгаль орчин, хөгжлийн асуудлаархи НҮБ-ын бага хурал, түүнээс гаргасан баримт бичигт тод тусгалаа олсон билээ.

"Экологийн загвар болох нутаг дэвсгэрийн олон улсын сүлжээ" байгуулж, түүнд Монгол улсын нутаг дэвсгэрийг олон улсын хамгаалалттай дэлхийн шим мандалын тусгай бүсийн статустайгаар хамруулах санал манай улс уг хурал дээр дэвшүүлсэн билээ. Бага хурлаас хойшхи хоёр жилийн хугацаанд дэлхий дахинд байгаль орчныг хамгаалах талаар нааштай арга хэмжээ авагдаж, шинэ соргог санал дэвшигдэх боллоо. Энэ оны 4-р сарын эхээр Парис хотноо болсон 122 орны 500 гаруй гишүүд оролцсон Олон улсын парламентайн холбооны (ОУПХ) 91-р чуулганаар хог хаягдалыг улс орон бүр өөрийн нутаг дэвсгэртээ л устгаж байх, түүнийг далай тэнгэст хаяхыг хүн төрөлхтөний эрх ашгийн үүднээс хориглох нь зүйтэй гэж тусгай тогтоол гаргав. Энэ нь тив дэлхий, бүс нутагт эдийн засгийг хөгжүүлэх аливаа асуудлыг авч ярихдаа заавал экологийн асуудалтай холбон

мөн үзэж байх гэсэн эрмэлзлэл хүчтэй болж буйн жишээ юм.

Эдүгээ дэлхий дахин, тив, бүс нутгийн аж ахуйн хэлхээ холбоо интернационалчлагдаж, шинжлэх ухаан-техникийн хувьсгал нийтийг хамран, мэдээлэл ба харилцаа холбооны хэрэгсэл зарчмын цоо шинэ үүрэгтэй болж байна. Хөгжингүй болон шинээр үйлдвэржсэн орнуудад эрдэм оюун их шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг өргөн хүрээтэй явуулсны үр дүнд хөдөлмөрийн шинж чанарт өөрчлөлт орж, хүмүүсийн ахуйн хэрэгцээг хангах чиглэл хүчтэй болж байна. Шинжлэх ухаан-техник, технологи, үйлдвэрлэлийн салбар дахь хөгжлийн энэхүү хандлага нь дэлхийн улс орнуудын хооронд явагдаж буй эдийн засгийг интеграцичлах нийт бөмбөрцгийн үйл явцын хүрээнд хэрэгжиж байна. Зарим бүс нутагт үзэгдэж буй дезинтеграцичлах үйл явц үүнд сөрөг нөлөө үзүүлэх боловч ерөнхий хандлага эрч хүчийг авсаар байгаа билээ.

Дэлхийн нийтийн өнөөгийн хөгжлийн нэг онцлог бол улс төрөн бөмбөрцгийн асуудлыг, ялангуяа эдийн засгийн асуудлыг шийдвэрлэхэд хувь нэмрээ оруулах үүднээс өөрсдийн аж төрөн суугаа нутаг орнуудынхаа хөгжилд талхтг анхаарал хандуулан бүс нутагчилах (регионализмын) үзэл санааг дэлгэрүүлэн хэрэгжүүлэх болсон явдал юм. Тиймээс тив дэлхийг өрнөт-дорнот, умарт-өмнөт гэж хуваах үзэл баримтлал утгаа алдах шинж төлөв улам тодорхой болж байна. Манай гаригийн улс гүрнүүд цаашид бүс нутгуудад төвлөрсөн хэд хэдэн том туйлд хуваагдаж болохыг ч үгүйсгэх аргагүй. Өнөөгийн байдлаар Европын орнууд нэгдсэн зах зээлтэй болж Европын холбоонд нэгдэв. АНУ, Канад, Мексик улс хамтран "Умард Америкийн чөлөөт худалдааны хэлэлцээр" (НАФТА) байгуулав. "Африкийн эдийн засгийн хамтын нийгэмлэг" зохион байгуулах хурал болж, "Арабын эдийн засгийн блок" байгуулах уриа дуудлага сонсдох болов.

XX зууны эцсээр эдийн засгийн потенциалгаа өсгөн нэмэгдүүлж, аж ахуйн хөгжлийн өндөр хурдацаар дэлхий дахины анхаарлыг татаж, XXI зуунд манай гаригийн хамгийн хурдан хөгжих бүс нутаг болох төлөвтэй Ази тив, Номхон далайнсав газарт бүс нутагчилах үзэл санаа мөн дэлгэрч

хэд хэдэн бүс нутаг бүрэлдэн, эдийн засгийн хамтын ажиллагаа өрнөж ирсэн билээ.

Ази, Номхон далайн бүс нутагт "хүйтэн дайн" дуусгавар болсноос хойших жилүүдэд цэрэг-улс төрийн болон үзэл суртлын хурцадмал байдал намжих үндсэн хандлага бий болов. Бас тэндэхийн орнууд ялангуяа голлох орнуудад эдийн засаг-нийгмийн өөрчлөлт шинэчилэлт явагдаж, зарим талаар бүтцийн чанартай өөрчлөлтүүд гарч байгаа ажээ. Энэ бүхэн нь геополитикаас геоэкономикт шилжих үйл явцыг нөхцөлдүүлж, эдийн засгийн хөгжлийн асуудлыг төрийн бодлогын тэргүүн чиглэл болгон тавьж, энэ салбарт улс хоорондын хамтын ажиллагааг урагшлуулах чухал нөхцөлийг бүрдүүлж эхэлсэн байна.

1990-ээд оноос дэлхий дахины ба бүс нутгийн олон улсын харилцааны системд гарсан өөрчлөлтийн үр дүнд Ази, Номхон далайн аюулгүй байдлын асуудлаар олон талын яриа хэлцэл өрнүүлэн, үүнийг хэрэгжүүлэх механизм бий болгох бололцоо бий болж байна.

Ази, Номхон далайн орнуудын дэвшүүлсэн аюулгүй байдлын системийн энэхүү үзэл санаа нь өнгөрсөн үеийнхээс ялгаатай бөгөөд түүний хөгжилд хэд хэдэн шат байсан гэж судлаачид үздэг бөгөөд эдгээрийг товч өгүүлбэл:

-Дэлхийн 2 дайны дараах "хүйтэн дайны" жилүүдэд АНУ, ЗХУ-аар толгойлуулсан эсрэг тэсрэг хоёр лагерь оршиж байв. Ийм нөхцөлд 1950-иад онд АНУ-ын санаачилгаар (Япон, Өмнөд Солонгос, Филиппин, Австрали, Шинэ Зеланди) 6 орны "Зүүн өмнөд Азийн батлан хамгаалалтын гэрээний" (Манилын гэрээ гэж нэрлэгдсэн) байгууллага байгуулагджээ. ЗХУ, БНХАУ хоёр хамтарсан мэдэгдэл (1957) гаргаж цэргийн эвслийг "хамтын аюулгүй байдлын систем" болгон өөрчлөх санал дэвшүүлж байв.

-ЗХУ 1960-аад оны эцсээр "Азийн аюулгүй байдлын систем" (Дорнод Ази, Өмнөд Ази, Өрнөд Азийг багтаасан) байгуулах санал гаргажээ. АНУ, Хятад, Япон, Индонези, Пакистан зэрэг улс уг саналыг үл таашаасан учир хэрэгжээгүй.

1980-аад онд тус бүс нутгийн орнууд энд эдийн засгийн хамтын ажиллагааны механизм бий болгох санаачилга гаргав. ЗХУ өөрийн бодлогыг энэ шинэ нөхцөлд тохируулан, бүс нутгийн орнууд тухайлбал АНУ-тай харилцааны хурцадмал байдлыг намжаах алхмууд хийжээ.

1990-ээд онд ЗХУ задрал. Үүнтэй холбогдсон шинэ нөхцөлд Ази, Номхон далайн аюулгүй байдлын олон талын яриа хэлцлийн механизмыг (АПМСДМ) бий болгох эрэл хайгуул эхэлсэн юм. 1993 онд АСЕАН-ы орнуудын ГЯЯ-ны Сайд нарын 26-р бага хурал, дараа нь 7-р сард АСЕАН-ы орнуудын Сайд нарын зиндааны бага хурал (ПМС)-аар АПМСДМ-ийн тухай асуудал хэлэлцжээ. Сүүлийн бага хуралд ОХУ, БНХАУ-ын ГЯЯ-ны Сайд нар оролцжээ. Бага хурлаас гаргасан мэдэгдэлд АСЕАН-ы бүс нутгийн чуулга (АРФ) байгуулах тухай зарлаж чуулганы бүрэлдхүүнд АСЕАН-ы 6 орон дээр нэмж АНУ, Канад, Австрали, Шинэ Зеланди, Өмнөд Солонгос, БНХАУ, ОХУ, Вьетнам, Лаос, Папуа Шинэ Гвиней, Европын хамтын нийгэмлэг (ЕС) зэрэг 17 орон улсын байгууллагыг оруулах болжээ. АСЕАН-ы Бүс нутгийн Чуулганы (АРФ) анхдугаар бага хурлыг 1994 онд Бангкокт хийхээр ПМС-ийн бага хурлаар тогтжээ. Энэ нь урьд гарч байгаагүй үйл явдал болох бөгөөд түүхэнд анх удаа Ази, Номхон далайн аюулгүй байдлын олон талын яриа хэлцлийн механизмын асуудлыг Засгийн газрын төвшинд албан ёсоор авч үзэхээрээ онцлог болох билээ.

1993 онд болсон өөр нэг анхаарал татсан үйл явдал бол АНУ-ын ерөнхийлөгч Токиод болсон долоон их гүрний дээд хэмжээний уулзалтын дараа Өмнөд Солонгост айлчилахдаа 1993 оны 7-р сард "Азийн аюулгүй байдлын олон талын яриа хэлцлийг урагшлуулъя" гэсэн сэдэвтэй үг хэлж, тэндээ Номхон далайн хамтын шинэ нийгэмлэг байгуулах санал дэвшүүлсэн байна.

Дээр дурьдсанаас үзвэл Ази, Номхон далайн бүс нутагт улс орнуудын аюулгүй байдлын асуудлыг хэлэлцэж байх олон талын яриа хэлцлийн байгууллага байгуулах үзэл санааг бодит байдал болгох чухал алхам хийх суурь тавигдаж эхлэв.

Номхон далайн Хамтын Нийгэмлэг байгуулах асуудал бол нэлээд нарийн төвөгтэй бөгөөд амаргүй зорилт юм.

Хамтын нийгэмлэг нь нэг талаас өндөр хөгжилтэй ба буурай, баян ба ядуу, дотооддоо өөр өөр системтэй болон нийгмийн хөгжлийн загвар (парадигмийн) сольж байгаа орнууд; нөгөө талаас Ази тив, Номхон далайн сав газарт үйл ажиллагаа явуулж байгаа олон улсын хамтын ажиллагааны байгууллага зэргийг хамтран багтаах байх. Иймд эдгээр орон, байгууллагыг адилхан хөндөх нийтлэг ашиг сонирхлыг илрүүлэн олж, түүний үндсэн дээр хамтын ажиллагааг эхлэн өрнүүлэх шаардлага гарна. Ийм ашиг сонирхол нь юуны өмнө тус бүс нутгийн худалдаа, хөрөнгө оруулалтын асуудалд төвлөрч болох юм. Үүний хамт тэмдэглэхэд Ази тив, Номхон далайн сав газрын олонх улс оронд таваарын үйлдвэрлэлийг хөгжүүлэх талаар хамтын ажиллагааг хөгжүүлэх нь худалдаа, хөрөнгө оруулалтаас дутахгүй ач холбогдолтой байж болох талтай. Номхон далайн Хамтын Нийгэмлэгийг байгуулахад орчин үеийн үр дүнтэй хамтын ажиллагааны нэгэн хэлбэр болж буй Европын орнуудын холбооны Маастрихтын хэлэлцээрийн өмнөх ба хойших туршлага сургамж, мөн түүнчлэн Ази, Номхон далайн орнуудын АСЕАН, АПЕК зэрэг байгууллагын хичээл сургамжийг судлан ашиглах явдал гарах ёстой. Энэхүү Хамтын Нийгэмлэг нь бүс нутгийн бүх орныг эгнээндээ багтаахдаа ямар шинжийн байгууллага-Засгийн газрын уу, эсвэл Засгийн газрын бус байгууллага байх уу гэдгийг тогтоох зэрэг асуудлууд гарах бизээ.

Номхон далайн Хамтын Нийгэмлэг байгуулах тухай саналыг 1994 оны 5-р сард Сеул хотноо болсон Зүүн хойт Азийн эдийн засгийн хамтын ажиллагааны нийгэмлэгийн симпозиум өөрийн хэлэлцэх хэргийн төлөвлөгөөнд оруулан санал солилцоод ийм хамтын нийгэмлэг байгуулах боломж одоогоор байхгүй, энэ нь эртэдсэн санаа гэж симпозиумд оролцсон эрдэмтэд, улс төрчид үзсэн байна. Дашрамд тэмдэглэхэд симпозиум эдийн засгийн хамтын ажиллагаа, эдийн засгийн бүсийг харьцангуй жижиг бүс нутагт, цөөн орнуудын ашиг сонирхолд нийцүүлэн хөгжүүлэх нь илүү боломжтой бөгөөд үр дүн өгнө гэсэн саналыг мөн илэрхийлжээ.

Ази тив, Номхон далайн сав газрын өргөн удам нутагт Зүүн хойт Ази бие даасан бүс нутаг болон бүрэлдэх үйл явц

далаад хэдэн жилийн өмнө эхэлж, эдийн засагчид, улс төр судлаач эрдэмтдийн хүрээнд бүсэд багтах улс орнуудыг тодорхойлон тогтоож (Япон, БНСУ, БНАСУ, БНХАУ, Монгол, ОХУ, АНУ, Канад) улс төр, эдийн засаг, соёлын салбарт хамтран ажиллахын чухлыг үндэслэн онол-практикийн асуудлуудыг хэлэлцэн санал зөвлөмжүүд боловсруулах болсон байна. Зүүн хойт Азид олон талын хамтын ажиллагааг бий болгох асуудлууд нь бүс нутгийн аюулгүй байдлын системийг тогтоохтой салшгүй холбоотой юм. Бүс нутгийн хамтын ажиллагааны энэ тулгамдсан асуудал нь нийт Ази, Номхон далайн аюулгүй байдлын олон талын яриа хэлцлийн механизм (АПМСДМ) бий болгох өргөн асуудлын нэг бүрэлдэхүүн хэсэг болох ёстой. Асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн зайлшгүй алхам хийхэд бүсийн голлох орнууд үндсэн үүрэг гүйцэтгэх тухай онцлон тэмдэглэдэг явдал зүй ёсны зүйл бөгөөд АНУ, Япон, ОХУ, БНХАУ зэрэг орны удирдагчид уг асуудлыг нэг бус удаа хөндсөн. 1994 онд Бангкокт болох 17 орон, байгууллагыг еертөө багтаасан АСЕАН-ын Бүс нутгийн чуулганы (АРФ) санал бодол, шийдвэр үүнд нэн чухал ач холбогдолтой байх болно.

Өрчин үед эдийн засаг олон улсын харилцаанд зонхилох хүч болон дэвшигдэж, улс орнуудын бодлогын тэргүүн зэргийн зорилго нь эдийн засгийг хурдан хөгжүүлэхэд чиглэгдэх болсон нөхцөлд Зүүн хойт Азийн бүс нутгийн олон талын хамтын ажиллагааны нэг чухал чиглэл нь эдийн засгийн хамтын ажиллагааны асуудал болж байна. Энэ асуудлыг анх сэдэх, судалгаа хийх, санал зөвлөмж боловсруулах ажил судлаач эрдэмтдийн хүрээнээ явагдаж эхэлсэн байна. Энэ үйл хэрэгт чухал хувь нэмрийг анхлан АНУ-ын Гавайн арлын Гонолулу хотын "Дорно-Өрнө төв" оруулж, Гавайн арлын Ази Номхон далайн институт, Зүүн хойт Азийн эдийн засгийн чуулгатай хамтран эрдэм шинжилгээний цуврал бага хурлууд зохиосон юм. Хожмоо "Чанчуны" гэж заримдаа нэрлэгдэх болсон ийм бага хурлууд 1989 оноос зохиогдов. Тэдгээрт бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны нийтлэг ерөнхий болон зарим тодорхой асуудлууд хэлэлцэж санал бодлоо илэрхийлж байсан бөгөөд мөн хурлуудад улс төрчид, бизнесмены

төлөөлөгчид оролцох болжээ. Цуврал бага хурлаас анх Орос, Хятад, Умард Солонгосын нутгийн хэсгийг хамарсан Түмэн голын сав газрыг ("Алтан бэлчир") хөгжүүлэх санал дэвшүүлж, дараа нь түүнийг НҮБ-ын хөгжлийн хөтөлбөр Түмэн голын сав газрыг хөгжүүлэх төлөвлөгөө төсөл болгон зарлаж, түүнд бүс нутгийн бусад орон Япон, Өмнөд Солонгос, Монгол оролцох болсон билээ. Энэ төсөл эдүгээ алгуур удаавтар боловч хэрэгжих шатнаа оржээ. Зүүн хойт Азийн тодорхой бүс нутгуудыг хөгжүүлэх нэлээд төсөл гарсан бөгөөд тэдгээрийн дотор Түмэн голын төсөл нь гол байр суурийг эзлэж байна. Бүс нутгийн эрдэмтэн судлаачид, ажил хэргийн хүмүүс дурдсан зүйлээс иш үндэс авч бүс нутгийн улсуудын дотор эдийн засгийн хамтын ажиллагааны асуудлаар санал солилцон маргалдах цаг үндэсэндээ шувтарч практик дээр хамтран ажиллах цаг ирсэн гэдгийг 1992 онд Владивостокт болсон 4-р цуврал хурал дурдсан билээ. Гэвч бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааг өрнүүлэх худалдаа, зээл, хөрөнгө оруулалт гэх мэт аж ахуйн гол салбарт хоёр талын харилцаа голлож олон талынхи зохих хөгжлийг олоогүй байна. Эдийн засгийн олон талын харилцаа, өргөн хамтын ажиллагааг зохион байгуулан, олон талын яриа хэлцэл явуулах байнгын механизм бий болоогүй байна. Үүнд засгийн газрын бүс байгууллагуудын үйл ажиллагаа ихээхэн үүрэг гүйцэтгэх бөгөөд тэдгээрийг Засгийн газрын зүгээс дэмжих нь нэн чухал юм гэдгийг судлаачид онцлон дурьддаг байна. Жишээ нь өмнө дурьдсан Зүүн хойт Азийн эдийн засгийн хамтын ажиллагааны нийгэмлэгийн симпозиум: бүс нутагт эдийн засгийн хамтын ажиллагааг хөгжүүлэхэд тэнд оршин буй орнуудын засгийн газрын хооронд яриа хэлцлийг явуулах, яриа хэлцлийн байнгын механизм бий болгох явдал өнөөгийн тулгамдсан зорилт болж байна гэж үзэв. Бүс нутгийн хэд хэдэн улсын хооронд эдийн засгийн чөлөөт бүс байгуулах үйл явц удааширч байгаагийн нэг шалтгаан нь ийм механизм бий болж чадаагүйтэй холбоотой бөгөөд энэ нь бас бүс нутгийн зарим орны байр суурь, бодлогоноос шалтгаалах тал бий гэж тэмдэглэсэн юм. Энэ чиглэлээр Засгийн газрын шугамаар хоёр талын болон олон

тэний яриа хэлцлийг өрнүүлэх шаардлага зүй ёсоор урган гарч байна.

Дээр дурьдсанаас үндэслэн дүгнэхэд Зүүн хойт Азийн бүс нутагт эдийн засгийн хамтын ажиллагааны албан ёсны болон улсын байгууллага байгуулах явдал тулгамдсан зорилт болсон бөгөөд ийм байгууллага, механизмыг бий болгох объектив, субъектив нөхцөл бүрэлджээ гэж үзэж болгох байна.

Зүүн хойт Азийн эдийн засгийн хамтын ажиллагааны бичгийн байгууллага бий болгохтой холбогдсон зорилтыг хэрэгжүүлэхэд дараа дурьдсан зарим нэгэн хүчин зүйлсийг анхааран үзүүштэй. Бүс нутгийн орнуудын эдийн засгийн харилцан нөлөөлөл хүчтэй болж, үндэсний хил хязгаарыг шинэ гарсан үйл явц өрнөх болсон өнөөгийн нөхцөлд бүс нутаг дахь нэгтгэх хандлага нь задлах хандлагаас илүү амгалан болсныг хамтын ажиллагааны өнөөдрийн дэглэлийн хувьсал өрнөл харуулж байна. Бүс нутгийн орнуудын парагматив үзэл бодол дээр суурилсан, интеграци руу тэмүүлсэн хүчийг зах зээлгүйгээр төсөөлөх боломжгүй юм. Зах зээлийг баримжаалсан эдийн засгийн хамтын ажиллагааны хандлага нь хил хязгаар үл харгалзан болон талын худалдаа, хөрөнгө оруулалтаар дамжсан эдийн засгийн интеграцид тохирох бөгөөд энэ хандлага нь интеграцийн доод хэмжээ, улс төрийн хязгаарлагдсан хэлтэй холбоо болон харилцан аюулгүй байдлын үзэл баримтлалаар тодорхойлогдох юм. Тус бүс нутгийн орнуудын худалдаа дэлхийн худалдаанаас ихээхэн таагаралтай тул дэлхийн эдийн засаг хямралд орвол энэ бүс нутагт урьдчилан тааварлахад хэцүү үр дагавар хүргэнэ. Худалдаанд элдвээр саад хийх, протекционист бодлого явуулах, амин хувиа хичээх зэрэг худалдааны албиан бүс аливаа бодлого бүсийн аюулгүй байдалд ч мөн аюул болгох юм. Иймээс улс төрийн сөргөлдөөний үр дүнд бий болсон онц өрсөн үеэс уламжлалтай бэрхшээлийг арилгахад бүхэл олно анхаарал хандуулах нь чухал юм. Орчин үед дэлхийн аюулгүй байдал нь зөвхөн үндэсний батлан хамгаалах хүч чадлаар хязгаарлагдахгүй хүн ардад сайн амьдрал авчрах эдийн засгийн хүч чадлаар

тодорхойлогдох болж байна. Энэ нь үндэсний аюулгүй байдлын эдийн засгийн бүрэлдэхүүн хэсэг нь цэрэг зэвсгийн бүрэлдэхүүн хэсгээс дутуугүй ач холбогдолтой болж байгаа гэсэн үг.

Зүүн хойт Азийн бүс нутгийн аюулгүй байдал гэдэг бол бүс нутгийн тогтвортой байдлыг хадгалах гэсэн үг бөгөөд энэхүү тогтвортой байдал нь бүс нутгийн эдийн засаг, улс төр, нийгэм, соёлын дэвшилтэнд суурилсан урьдчилан харж болох хөгжлийн үйл явц биз ээ. Иймээс тогтвортой байдал нь бүс нутгийн тодорхой хэсэгт зонхилох байр суурь олж авах гэсэн аль нэг улс гүрний оролдлоготой үл нийцнэ. Хэрэв ийм оролдлого гарвал энэ нь бүс нутгийн хүчний тэнцэлд өөрчлөлт оруулан түүнийг эвдлэх нөхцөлийг бий болгох аюултай нь ойлгомжтой.

Интеграцын асуудлыг шийдвэрлэхэд субъектив хүчин зүйлүүд, тухайлбал түүхэн үйл явц дахь тодорхой хүмүүсийн үйл ажиллагаатай холбогдсон субъектив хүчин зүйлүүд идэвхтэй үүрэг гүйцэтгэж ирснийг тэмдэглэх хэрэгтэй. Нэгдэл нягтралын талыг баримтлагч улс төрийн зүтгэлтэн нарын хүчин чармайлт 80-аад онд Ази, Номхон далайн болон Зүүн хойт Азид эдийн засгийн хамтын ажиллагааны үйл явцыг эхлүүлэн хөгжүүлэхэд шийдвэрлэх үүрэг гүйцэтгэсэн Тэгвэл 90-ээд оны дунд үед хамтын ажиллагааны үйл явц ямар байх вэ гэдэг нь тус бүс нутгийн улс төрийн зүтгэлтэн нар бие биеийг ойлгон, харилцан хийх буултуудыг олж тохиролцох ур ухаан, хүчин чармайлтаас ихээхэн хамаарах биз ээ. Энэ нь төр, засгийн тэргүүнээс эхлээд олон талын сонирхлыг хөндсөн шийдвэрүүдийг бэлтгэх бүх шатны хэлэлцээний үйл явцад оролцогч дунд шатны ажил хэрэгч олон тооны ажилтан нарын аль алинд холбогдох юм.

Зүүн хойт Азийн бүс нутагт өнөөгийн хөгжлийн төвшин, дотоод дахь нийгмийн байгуулал, түүх-соёл-зан заншлын уламжлалаар харилцан адилгүй орнууд газар нутгийн байршлалын эрхээр багтан, харилцан үйлдэл, хамтын ажиллагааны бүс нутгийн сүлжээнд орж байна. Эдгээр орон хоёр тал ба олон талын харилцааг хөгжүүлэхдээ тус бүрийн хөгжлийн онцлогтой холбогдон бие биеийн дутууг харилцан нөхөж, бие биедээ дэм тус үзүүлэх, улс орон - бүс

нутгийнхаа хөгжлийг урагшлуулан түргэтгэх, энэ утгаараа бөмбөрцөгийн хамтын ажиллагааг урагшлуулах харилцанхамаарлын тогтолцоог бүрэлдүүлэх юм. Гэхдээ эдгээр тус бүрийн хүч бололцоо, потенциал, хүрсэн төвшин эхлэлтэй тул бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны өнөөдрийн ба ирээдүйн хөгжилд уг нутагт оршин буй орнууд, ялангуяа тэргүүлэх орнууд их үүрэг гүйцэтгэж, багаги хариуцлага хүлээнэ.

Түүнийг иш үндэс болгон бүс нутгийн орнуудын геополитик, геэкономикийн бодлогын зарим нэгхэн асуудлыг товч хөндөө.

Өнөөдөр дэлхий дахины бодлогын гол чухал асуудлууд, тэдгээрийн дотор Зүүн хойт Азийн асуудлууд Америкийн нэгдсэн улсын оролцоогүйгээр үл шийдэгдэнэ гэдэг нь тодорхой.

АНУ дэлхийн 2-р дайны дараа Ази, Номхон далайн бүс нутагт хоёр талын холбооны өргөн сүлжээ тогтоож батлан хамгаалах стратегиа хэрэгжүүлсэн юм. Дэлхийд манлайлах байр суурь баримтлан, эдийн засгаас илүү цэргийн хүч чадлыг хөгжүүлэхэд голлон анхаарч байв. Аажимдаа холбоотонтойгоо харилцах харилцаандаа манлайлан давамгайлах байр сууринаас тэдэнтэй яриа хэлцэл хийж, чөлг шугамаа зохицуулах байранд шилжих болжээ. Ази, Номхон далайн хамтын ажиллагааны үзэл санаа үүсэн гарч байхад АНУ түүнийг таашаан үзэхгүй байсан хандлагаа хэвчлэн нь өөрчилөв.

1990-ээд онд Зөвлөлт улс задарсантай холбогдуулан түүний цэргийн аюулын эсрэг чиглэсэн Ази, Номхон далай дахь хуучин стратегиас АНУ холдож эдийн засгийн асуудлын ач холбогдлыг товойлгон тавих болж, Ази, Номхон далайн шинэ стратегиа томъёолжээ. Энэ нь эдийн засгийн интеграцийг хэрэгжүүлэх ардчилах үйл явцыг дэмжих батлан хамгаалах шинэчилсэн бүтцийг бий болгох үзэл санаанд үндэслэсэн ажээ. Зүүн хойт Азийн хувьд гэвэл АНУ нь АНУ-Японы цэргийн эвслийг аюулгүй байдлын стратегийн голт зүрх хэмээн үзэхийн хамт энх тайван харилцааг тогтоох үүднээс ОХУ, БНХАУ-тай урьдаас илүү зохицуулалт хийх үзэл бодол давамгайлах болжээ. АНУ "хариуцлагыг бүтээлчээр хуваалцах" үзэл санаандаа

үндэслэн Номхон далайн хамтын нийгэмлэгт нийгэм-эдийн засгийн янз бүрийн систем бүхий, хөгжлийн янз бүрийн төвшинд байгаа орнуудыг багтаах саналыг зөвшөөрөх болжээ. Үүнийг өнгөрсөн оны дундуур ба сүүлчээр ерөнхийлөгч Б.Клинтоны дэвшүүлсэн Номхон далайн хамтын нийгэмлэг байгуулах тухай санал, АПЕК-ийн гишүүн орнуудын дээд хэмжээний уулзалтын дүнгийн талаар өгсөн үнэлэлт дүгнэлт дахин харууллаа.

Нэгдсэн Ази, Номхон далайн бүс нутаг Америкийн улс төр, эдийн засгийн урт хугацааны сонирхолд нийцэнэ гэж АНУ үзэж буй. Энэ сонирхолтой нь бүс нутагт гадаадын хүч нэвтрэхэд саад тавьж, протекционизмын бодлого явуулах гэсэн Ази дахь хүчний байр суурь зөрдөг юм. Тэгэвч Азийн аюулгүй байдлыг хангахад АНУ-ын идэвхтэй оролцлогоо хэрэгтэй гэдгийг АНУ-ын манлайлах эрмэлзлэлийг эмзэг хүлээн авдаг Азийн улс төрийн хэсгийнхэн ч ухамсарлаж буй. АНУ, Япон хоёр улс туншүүд боловч тэдний хоорондын эдийн засаг, худалдааны маргаан өссөөр бөгөөд мөн ийм төрлийн маргаан АНУ, Зүүн Азийн орнуудын хооронд үргэлжилсээр байгаа юм.

Ази тив, Номхон далайн сав газар. Зүүн хойт Азийн бүс нутгийн байдлын цаашдын тогтворжилт, тэндэх аюулгүй байдлын систем, олон талын эдийн засгийн хамтын ажиллагааны үйл явц өргөжин хөгжих явдал АНУ-ын хандлага, чиг шугамаас ихээхэн хамаарна. Эдүгээ АНУ, Азийн харилцаа нэн чухал өөрчлөлтийн шинэ шатнаа гарч байгаа бөгөөд энэ нь цаашид нэгдсэн Азийн бодит байдалд тохирон эерэг тал өөд сайжран өрнөнө гэдэг итгэлийг төрүүлж байна.

АНУ-ын засаг захиргаа Монголд өрнөсөн нийгмийг ардчилах, зах зээлийн эдийн засагт шилжих үйл явцыг дэмжиж манай оронд эдийн засаг-санхүү, хүмүүнлэгийн тусламж үзүүлж байна. Монголд хандивлагч гол орнуудын нэг-АНУ-ын энэ найрсаг хандлага, дэмжлэг тусламж нь манай эдийн засаг, хөдөлмөрчдийн амьдралд тохиолдож буй өнөөгийн хямралын үйл явцыг аль болох богино хугацаанд гэтлэн туулж эдийн засгаа тогтворжуулан цаашид өрнөлийн замд гаргах үйл хэрэгт чухал хувь нэмэр болох билээ.

Өндөр хөгжилтэй, эдийн засгийн үлэмжхэн потенциалтай Япон улс Зүүн хойт Азийн хамтын ажиллагаанд гол үүрэг гүйцэтгэх орны нэг юм. Сүүлийн үед Японы байр-суурь бэхжиж, түүний эдийн засгийн нөөц нэмэгдэн олон улсын тавцанд гүйцэтгэх үүрэг, түүнд тавих дэлхийн нийтийн найдлага өсөн нэмэгдсээр байна. Одоо Япон дэлхийн үйлдвэржсэн долоон том орны нэг бөгөөд НҮБ-д оруулах хөрөнгийн хэмжээгээр АНУ-ын дараа орох болж, хөгжлийн төвшин доогуур орнуудад санхүү-эдийн засгийн тусламж дэмжлэг үзүүлэх талаар дэлхийд тэргүүлэх болжээ. Японы санхүү, эдийн засаг-технологийн энэхүү боломжийг Зүүн хойт Азийн бүс нутгийн зарим улс, тэдний дотор Монголын хөгжлийг түргэтгэхэд хоёр талын ба олон талын хамтын ажиллагааны хүрээнд ашиглах явдал ач холбогдолтой юм. Сүүлийн үед Японы Засгийн газар Монголд зах зээлийн эдийн засгийг хөгжүүлэхэд нэн идэвхтэй дэмжин туслаж байгаа билээ. Ялангуяа хандивлагч улс орон, олон улсын байгууллагын уулзалт зөвлөлгөөнийг удаа дараа санаачлан хийлгэж Монголыг хөгжүүлэхэд их анхаарч байна. Япон улс дангаар болон АНУ-тай хамтран Зүүн хойт Азийн тодорхой бүс нутгуудыг хөгжүүлэх талаар боловсруулсан төслүүд нь бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааг урагшлуулахад хувь нэмэр оруулж буй билээ. Япон өөрийн оршин буй бүс нутагт улс төр, эдийн засгийн манлай улс болох тэмүүлэлтэй байгаа нь нийтэд илэрхий. Энэ зорилтоо хэрэгжүүлэхэд нь нэг талаас АНУ-тай тогтоосон түншлэлээ хадгалах явдал, нөгөө талаас бүс нутгийн зарим оронтой харилцах харилцаан дахь хоёр талын ашиг сонирхлыг хондсон зарим асуудлаа шийдвэрлэх явдал багагүй нөлөө үзүүлэх бизээ.

Зүүн хойт Азийн бүс нутгийн хамтын ажиллагааны нэг том түнш бол Орос улс юм. Бодит байдлаас үзвэл өнөөгийн Оросын холбооны улс нь: -Европ, Умард Номхон далай дахь чухал нөлөө бүхий бүс нутгийн их гүрэн юм. Цөмийн зэвсгийг хориглон устгах хүртэл Орос улс, АНУ ба БНХАУ-тай адил цөмийн гүрэн хэвээр үлдэнэ. Орчин үеийн эдийн засгийн банд бэрхшээлийг үл харгалзан ОХУ эдийн засгийн үлэмж потенциалтай том гүрэн хэвээр байгаа бөгөөд байх нь мэдээж. Энэ нь тус орны байгалийн их нөөц, мэргэжсэн

ажиллах хүч, оюуны потенциал, соёл-шинжлэх ухааны хөгжлийн өндөр төвшинөөр тодорхойлогдож байна. Түүнчлэн Орос дотоодын асар том зах зээл бий. Ийм байр суурь болон бололцоо потенциалтай Орос орон Зүүн хойт Азийн эдийн засгийн хамтын ажиллагаа, интеграцид оролцохдоо: юуны өмнө Оросын Алс Дорнодын бүс нутгийн хөгжүүлэхэд их анхаарал тавьж байна.

Алс Дорнодынхоо нэлээд хэсгийг нээлттэй болгож, тэнд байгаа зэвсэгт хүчээ багасгах арга хэмжээ авч бүс нутгийн хүчний тэнцвэрийг үл алдагдуулахад чухал алхам хийж байна. Орос улс Зүүн хойт Азийн улс оронтой хоёр талын болон олон талын харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлж ирсэн бөгөөд тухайлбал БНХАУ, БНАСАУ-тай хамтран Түмэн голын сав газрыг хөгжүүлэх олон улсын төсөл хэрэгжүүлэхэд оролцон, бүс нутгийн олон улсын байгууллагуудтай хамтран ажиллахыг эрмэлзэж байна. Орос улс АСЕАН-ы Бүс нутгийн чуулгын (АРФ) бүрэлдэхүүнд багтаж орсноор Ази, Номхон далайн аюулгүй байдлын олон талын яриа хэлцлийн асуудлыг нааштай шийдвэрлэхэд хувь нэмэр оруулах ёстой. Энэ бүгдийг тооцон үзвэл ОХУ нь Ази, Номхон далайн тогтвортой байдлыг бэхжүүлэхэд урьдаас илүү чухал үүрэг гүйцэтгэх боломжтой юм.

Бүс нутгийн зарим оронтой тогтоосон харилцаанд цаашид шийдвэрлэх асуудал ОХУ-д байгаа бөгөөд эдгээрийг бүс нутгийн хамтын ажиллагааг урагшлуулах нийтлэг зорилгод нийцүүлэн зохицуулах нь чухал болж буй.

1994 оны 7-р сард ОХУ-ыг "Их долоогийн" Неаполийн чуулганд наймдах түнш болгон урин оруулсан явдал орчин үеийн олон улсын харилцаанд ОХУ-ын эзлэх байр суурийг тодруулан улс орны дотоод дахь бэрхшээлтэй асуудлаа шийдвэрлэхэд нь тус дэм болох юм.

Монгол, Орос хоёр орон хил нийлсэн хөршүүд төдийгүй урт хугацаанд холбоо хэлхээ, харилцан хамааралтай оршин тогтнож ирсэн түүхтэй. Хоёр улс төлөвлөгөөт төвлөрсөн эдийн засгийн системээс зах зээлийн эдийн засагт шилжих энэхэн үед монгол-оросын харилцаанд багагүй бэрхшээл тулгарч байна. Эдгээр бэрхшээлийг даван туулах талаар хоёр талаас тодорхой алхмууд хийж, уламжлалт харилцаагаа сэргээн шинэтгэх чигт хоёр улсын Засгийн газар

хөтдөр ажиллаж байгаа нь манай орны олон нийтийн амьдралыг зүй ёсоор татаж буй.

Зүүн хойт Азийн бүс нутгийн хамтын үйл ажиллагаанд манай улс үүрэг гүйцэтгэж буй улсын нэг нь БНХАУ мөн. Монгол улс өмнөд их хөрш БНХАУ-ын өөрчлөлт шинэчлэлт, тэтгэж олон улсын талбарт, ялангуяа Ази, Номхон далайн бүс нутагт явуулж буй бодлого, үйл ажиллагааг байнга ажиглан сонирхож байдаг юм. Сүүлийн жилүүдэд БНХАУ-ын гадаад эдийн засгийн бодлогын чухал нэгэн чиглэл нь Зүүн хойт Азийн бүс нутагт хандаж байгаа билээ. Дэлхийн хамгийн олон хүн амтай, эдийн засаг-үйлдвэрлэлийн болон дээд-техникийн ихээхэн потенциалтай БНХАУ нь цаг үе улирах тутам Зүүн хойт Азийн бүс нутагт, түүгээр барахгүй Ази тив, Номхон далайн сав газарт улам бүр өсөн нэмэгдэх байр суурь эзлэх болно гэдэг нь маргаангүй. Энэ бол дэлхийн улс орон, ялангуяа бүс нутгийн улсуудын анхааран тусгаж зохих түүхэн бодит зүйл юм. БНХАУ-ын байр суурь, бодлогоос Зүүн хойт Азийн улс төрийн аюулгүй байдал, эдийн засгийн тогтвортон хөгжил үлэмжхэн хэмжээгээр хамраах юм.

БНХАУ эдийн засгийн шинэчлэлт, нээлттэй гадаад бодлого явуулах болсноос хойш Зүүн хойт Азийн орнуудтай эдийн засаг-худалдааны харилцаагаа идэжүүлж манай хойт мужуудаа хөгжүүлэх төлөвлөгөөг арав, арван сав, хорин таван жилээр зохион хэрэгжүүлэх болсон юм.

Хятадын зүүн хойт Азид хамрагдаж буй муж, бүс нутаг нь нийт Хятадын эдийн засагт чухал үүрэг гүйцэтгэдэг ажээ. Тухайлбал тэнд орчин үеийн аж үйлдвэр хамгийн эрт хөгжиж хүнд аж үйлдвэр зэгсэн төвлөрсөн юм.

БНХАУ ихээхэн идэвх гарган Зүүн хойт Азийн орнуудтай гол нь ОХУ, БНАСАУ-тай хамтран хэрэгжүүлж буй томоохон төслийн нэг нь Түмэн голын сав газрыг хөгжүүлэх төсөл юм. 15 жилийн хугацааг эзлэх энэхүү төслийг хэрэгжүүлснээр Хятад улс энэ бүс нутгийн орнуудтай харилцан ашигтай худалдааг хөгжүүлэх, эрдэс түүхий эдэд боловсруулалт хийх, эдийн засгийн чөлөөт бүс байгуулах гэх зэрэг шинэ бололцоог олж авах юм. Монгол улс БНХАУ-тай эдийн засаг-худалдааны харилцаа, хамтын ажиллагаагаа

өргөжүүлж, хилийн нэлээд боомтыг нээж, хятадын нутгаар дамжин далайд гарцтай болох эхлэл тавигдаж байна.

Зүүн хойт Азийн тогтвортой байдал, хамтын ажиллагаанд Солонгосын хойг дахь хоёр улсын нэгдмэл хүчин чармайлт өнөө үед нэн чухал болж байна. Солонгосын хойгт БНСУ, БНАСАУ хэмээх НҮБ-ын гишүүн хоёр улс оршиж, хоёулаа Зүүн хойт Азийн бүс нутгийн хамтын ажиллагаанд тодорхой байр суурь эзэлдэг.

Шинээр үйлдвэржиж, орчин үеийн зохих хүч, нөөцтэй болсон БНСУ Зүүн хойт Азийн бүс нутгийн олон талт хамтын ажиллагаанд идэвхтэй оролцож шинэ санаачилга гаргасаар байна. БНСУ гадаад бодлогдоо БНХАУ, ОХУ, Япон, АНУ-тай харилцах харилцаагаа тэлэн идэвхжүүлж байгаа нь тус бүс нутгийн тогтвортой байдалд чухал нөлөө үзүүлж байна.

Өнгөрсөн жилүүдэд БНСУ, Монгол улстай харилцах харилцаагаа өргөжүүлж, Монголын эдийн засагт үзүүлэх дэмжлэг тусламжаа нэмэгдүүлж байна. БНАСАУ, Монгол улстай тогтоосон олон жилийн уламжлалт харилцаагаа үргэлжлүүлэн хөгжүүлсээр байна.

Сүүлийн үед БНАСАУ цөмийн зэвсгийн байгууламж боловсруулан бүтээж буй тухай асуудал дэлхийн олон нийтийн анхаарлыг татсан юм. Энэ асуудалд ихээхэн ухаалаг болгоомжтой хандан зохицуулах нь Солонгосын хойгоор тогтохгүй Зүүн хойт Азийн бүс нутгийн хөгжлийн өнөөгийн ба ирээдүйн үйл явцад эерэг нөлөө үзүүлэх билээ. Энэ нь Солонгосын хойгийн хоёр орны харилцааг яриа хэлцлийн аргаар хэвийн болгоход тус дэм болно.

Зүүн хойт Азийн бүс нутагт багтдаг орнуудын нэг нь Монгол улс юм. Манай улс сүүлийн хэдэн жил бүс нутгийн хамтын ажиллагааны үйл явцад идэвхтэй оролцох эрмэлзлэлтэй ажиллаж ирэв. Монгол орны түүхэн хөгжил уламжлал өнөөгийн байдалд өвөрмөц зүйлс цөөнгүй.

Тус улс харьцангуй өргөн уудам нутагтай, байгалийн арвин баялагтай боловч хүн амаар цөөн. Өнгөрсөн долоон арав гаруй жилд орчин үеийн аж ахуйн систем бүрэлдүүлэх, үйлдвэрлэхүй хүчнийг хөгжүүлэх талаар нэлээдийг амжсан боловч өнөөгийн хүрсэн төвшинг ихэд дээшлүүлэх шаардлага хурц тавигдсаар буй. Энэ хугацаанд орчин үеийн

соёл, урлаг, боловсрол, шинжлэх ухааныг хөгжүүлэх талаар үерэнгүй ахиц гарган нийт иргэдийг бичиг үсэгтэй болгон, хүн амын боловсролын хэмжээг нийтэд нь дээдэлүүлсэн боловч дэлхийн шинжлэх ухаан-техник, технологийн орчин үеийн ололтоос хоцруу явж байгаа бөгөөд.

Монгол улсын нүүдлийн сонгодог бэлчээрийн мал аж ахуйн орон юм. Энэ аж ахуйн салбарыг эрхэлдэг монголын малчид бол нүүдэлчдийн соёл иргэншлийг аван явагчид бөгөөд манай ард түмний олон зууны турш энэ иргэншлийг дагалдан хүн төрөлхтний өмнө хүлээсэн үүргээ биелүүлсээр иржээ. Өнөөдөр энэхүү соёл иргэншлийг дэлхийн соёл иргэншлийн ололттой зөв хослон хөгжүүлэх, монгол орны байгалийн унаган төрхийг хамгаалах явдал ард түмний өмнө тавигдаж буй нэгэн түүхэн зорилт болж буй.

Монгол улс 1990-ээд оноос нийгмийн амьдралыг шинэчлэх, ардчилах, төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах-зээл баримжаалсан эдийн засгийн тогтолцоонд шилжих үйл явцыг өрнүүлэн нийгмийн байгууллалын загварыг сольж буй бүс нутгийн орнуудын нэг юм. Өрнөж буй өөрчлөлт шинэчлэлт орчин үеийн нөхцөлд зайлшгүй явагдах үйл явц мөн. Гэвч энэхүү шилжилт нь шинэ бөгөөд өөрийн хуримтлагдсан туршлагагүй, түүний дээр нийгмийн удирдлагын зарим дутагдалтай ба алдаатай ажиллагаагаар нөхцөлдсөн нийгэм-эдийн засаг, соёл, ёс суртахууны гүнзгий хямралыг дагалдуулсан үйл явц болон хэрэгжиж байна. Өнөө үед Монголын олон нийтийн анхаарлын төвд Улсын хөгжлийн үзэл баримтлал, жинхэнэ зах зээлд шилжих механизм зэргийг боловсруулах, бүтээх үйлдвэрлэлийг сэргээн хөгжүүлэхийн хамт боловсрол, шинжлэх ухаанд тэргүүлэх ач холбогдол өгөх зэрэг асуудал хурцаар тавигдаж байна. Монгол улс гадаад бодлогодоо тив дэлхийн бүх оронтой нээлттэй харилцах зарчмыг баримтлах болж, түүний нэг чухал чиглэл нь Зүүн хойт Азийн орнуудтай бүх талын, юуны өмнө эдийн засгийн харилцааг хөгжүүлэх явдал болов. Тэдгээр оронтой хоёр талын харилцаа хөгжүүлэх, ОУВС, ДБ, АХБ зэрэг олон улсын санхүү-эдийн засгийн байгууллагуудад гишүүнээр элсэн

хөгжлийн хөтөлбөрөө тохиролцох, хандивлагч орнуудын зээл тусламжийг авах зэргээр олон улсын дэмжлэг тусламжид дулдуудах болсон нь амсаж буй бэрхшээлийг гэтлэх нэг хичин зүйл болж байна.

Манай улсын эрдэмтэд, улс төрчид, ажил хэргийн хүмүүс эрдэм шинжилгээ-судалгаа, эдийн засаг-санхүүгийн практик ажлын олон улсын уулзалт, бага хурал, симпозиум, семинарт оролцон санал солилцохын хамт практик өгөөж бүхий төслүүдийг болвсруулан хэрэгжүүлэхэд оролцох болов. Манай улсын анхнаас оролцож буй бүс нутгийн томоохон төсөл бол Түмэн голын төсөл юм.

Манай эдийн засгийг уналтаас гаргаж хөл дээр нь босгон цааш хөгжүүлэхэд гадаадын хөрөнгө оруулалт чухал хүчин зүйл болох нь ойлгомжтой. Үүнийг харгалзан гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуулийг Парламентаар шинэчилэн батлав. Хөрөнгө оруулалтыг дэмжин хамгаалах тухай Засгийн газар хоорондын хэлэлцээрүүдийг олон оронтой, тэдний дотор Зүүн хойт Азийн олонхи оронтой байгуулав.

Монгол улс бүс нутгийн олон талын хамтын ажиллагааны байгууллагуудын үйл ажиллагааг байнга сонирхон ажиг байна. Саявтар "Ази, Номхон далайн эдийн засгийн хамтын ажиллагаа" (АПЕК) байгууллагад Монгол улсыг гишүүнээр элсүүлэх тухай хүсэлтийг илэрхийлсэн илгээлтийг Монгол улсын ерөнхий сайд тус байгууллагын гүйцэтгэх захиралд илгээсэн бөгөөд гишүүнээр элсэх бэлтгэлийг хангах зорилготой Үндэсний хороог байгуулан ажиллуулж байна.

Манай төрийн болон эрдэм шинжилгээний олон нийт Ази, Номхон далайн аюулгүй байдлын олон талын яриа хэлцлийн механизм бий болгох тухай Азийн орнуудын санаачилга, түүнтэй холбогдсон эрэл хайгуулын ажлыг талархан үзэж, энэ асуудлыг Засгийн газрын төвшинд хөндөн ярилцахаар төлөвлөгдөж буй АСЕАН-ы орнуудын Бүс нутгийн чуулгын (АР Ф) Бангkokын бага хурал их ач холбогдолтой болно гэж найдаж байна.

Өнөөдөр Монголд улс орноо Зүүн хойт Азийн бүс нутаг, улмаар Ази тив, Номхон далайн сав газрын эдийн засгийн хамтын ажиллагааны найдвартай, сонирхолтой түнш

Болгоход чиглэгдсэн хөрс дэвсгэрийг бүрдүүлэх үйл явц урагшилсаар буй. Энэ үйл явц бүс нутагт хамтын ажлаар байнгын механизм бий болж үйлчилж эхлэхэд улам идэвхжиж чиглэсэн зорилттой болох нь зайлшгүй. Хэрэг явдлын ийм эргэлт Монгол улсын хөгжил, түүний дотор эдийн засгийн дэвшилд өнөөдрийнхөөс хэсэг илүү эерэг нөлөө үзүүлж, түүний өрнөлтийн нэгэн зүйл болох билээ.